



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 501

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2018 он, 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 1,923.4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэж ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн дүнг 2020 оны дөрөвдүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

2.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргаж байх;

2.2. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтыг болон, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллах;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлж ажилласан тус компанийн удирдах болон бусад холбогдох албан тушаалтан нарт хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

3. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4. Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК-ийн захирал (Г.Балжинням)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

4.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг

1320114

худалдан авахдаа Төрийн өмчийг бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авч ажиллах;

4.3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчин санхүүгийн бүрдэл дутуу баримтаар хийгдсэн ажил гүйлгээний баримтыг нөхөн бүрдүүлэх,

4.4. Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаар тогтоолын 2.2-д төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох;

4.5. Компанийн 2017 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгийн дүнгээс төсөвт бүрэн төвлөрүүлээгүй 25.3 сая төгрөгийг ногдол ашгийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан улсын төсөвт төвлөрүүлэх;

4.6. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн  
50/ дугаар тогтоолын хавсралт



Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга		Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Балансад бүртгэлгүй /2016 онд данснаас хасагдсан/ үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдсан		Захирал Г.Балжинням, Ерөнхий ня-бо А.Цагаансар	22,956.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг дагаж мөрдөн ажиллах.
2	Зөвшөөрөлгүй худалдан авсан үндсэн хөрөнгө		Захирал Г.Балжинням, Ерөнхий ня-бо А.Цагаансар	191,260.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийг дагаж мөрдөн ажиллах.
3	Үндсэн баримтгүй зарцуулсан хөрөнгө	Гэрээ дүгнэсэн актгүй	Захирал Г.Балжинням, Ерөнхий ня-бо А.Цагаансар	61,748.20	Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
		Тушаал шийдвэргүй		75,696.10	
4	Хууль бусаар олгосон гадаад албан томилолтын зардал		Захирал Г.Балжинням, Ерөнхий ня-бо А.Цагаансар	4,763.60	Гадаад томилолтын зардлын талаарх журмыг мөрдөж ажиллах
5	Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй үргүй зардал		Захирал Г.Балжинням, Ерөнхий ня-бо А.Цагаансар	171,710.70	Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад заасан "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2 дахь заалтад "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" зэрэг заалтуудыг мөрдөн ажиллах.
6	Мөрдөж буй хууль тогтоомжийг зөрчин системийн дээд байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг санхүүжүүлсэн		Захирал Г.Балжинням, Ерөнхий ня-бо А.Цагаансар	1,336,570.00	2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилгын их засвар ажлыг тусгасан бөгөөд Эрчим хүчний яамны барилгын засварын зардлыг даасан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" 08 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах.
				33,390.27	Эрчим хүчний яамны холбогдох албан хаагчдын гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай" 08 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах.
7	Улсын төсөвт төвлөрүүлээгүй ногдол ашиг		Захирал Г.Балжинням, Ерөнхий ня-бо А.Цагаансар	25,335.00	Компанийн тухай хуулийг мөрдөж ажиллах
<b>Дүн</b>				<b>1,923,429.87</b>	